



**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2014 ОНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

2014.11.14

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
АНУ	Америкийн нэгдсэн улс
АТГ	Авлигатай тэмцэх газар
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НДЭХ	Нийгмийн дэвшил, эмэгтэйчүүд, хөдөлгөөн
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ХАСУМ	Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг
ХАСХОМ	Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХШДШХ	Хяналт, шалгалт, дүн шинжилгээний хэлтэс
ШСАА	Шадар сайдын Ажлын алба
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан

АГУУЛГА

НЭГ. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ	3
1.1. Эрхэм зорилго	3
1.2. Үйл ажиллагааны стратегийн зорилт	3
1.3. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл	3
ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА	4
2.1. Албан хаагчдын мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх ажил	5
2.2. Мэдүүлэг, мэдэгдэл бүрдүүлэлтийн ажил	7
2.3. Мэдээллийн ил тод байдал	8
2.3.1. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	9
2.3.2. Хүний нөөцийн бодлогын ил тод, нээлттэй байдал	20
2.3.3. Төсөв, санхүүгийн ил тод байдал	22
2.3.4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал	23
2.4. Авлигатай тэмцэх газартай хамтран ажилласан байдал	24
2.5. Дотоод хяналт, шалгалтын ажил	26
2.6. Байгууллагаас авч хэрэгжүүлсэн шинэ санаачилга, томоохон ажил	27
ДҮГНЭЛТ	33

НЭГ. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Худалдан авах ажиллагааны газар нь Монгол Улсын Шадар сайдын 2012 оны 42 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-г тусгагдсан дараахь эрхэм зорилго, стратегийн зорилтыг хэрэгжүүлж байна.

1.1. Үйл ажиллагааны эрхэм зорилго

Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай зохион байгуулахад оршино.

1.2. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Худалдан авах ажиллагааны газар нь эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан стратегийн зорилтыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Худалдан авах ажиллагааны тогтолцоо, удирдлагын болон бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэн хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох;
2. Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд тулгуурлан төлөвлөж, зохион байгуулан хэрэгжүүлэх, тайлагнах;
3. Худалдан авах ажиллагаанд менежментийн шинэлэг чиг хандлага, ур чадварыг хэрэгжүүлэх;
4. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх;
5. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, орон нутгийн нэгжүүдийг нэгдсэн удирдлагаар хангах.

Тус агентлаг нь тухайн жилийн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэхдээ дээр дурдсан үйл ажиллагааны эрхэм зорилго, стратегийн зорилтыг хангах хүрээнд Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Шинэчлэлийн Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2014 оны Үндсэн чиглэл, холбогдох үндэсний хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан холбогдох зорилт, арга хэмжээг уялдуулан хэрэгжүүлэхийн зэрэгцээ дараахь үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг баримтлав.

1.3. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

1. Худалдан авах ажиллагааны үр ашигтай тогтолцоог бий болгон хөгжүүлэх;
2. Худалдан авах ажиллагааны талаарх төрийн бодлого, зохицуулалтын хэрэгжилтийг зохион байгуулах;
3. Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд тулгуурлан төлөвлөж, зохион байгуулан хэрэгжүүлж, тайлагнах;
4. Худалдан авах ажиллагаанд менежментийн шинэлэг чиг хандлага, ур чадварыг ашиглах;
5. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх.

Дээр дурдсан бодлого, үйл ажиллагааны зорилт, чиглэлийг хэрэгжүүлэх ажлуудыг агентлаг, нэгжийн 2014 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, Төсвийн шууд захирагчийн болон хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийн үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжилтийг хагас жилээр дүгнэн, нэгжүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөг сар, улирлаар тодотгож, биелэлтийг тооцон ажиллаж байна.

Мөн түүнчлэн, Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагвын санаачилгаар 2013 онд “Сахилга, хариуцлага” сэдвийн дор зохион байгуулсан “Ард түмэн Та – Хаан” үндэсний форумаас гарсан уриалгыг 2014 оны үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх, Монгол Улсын Шадар сайдын 2014 оны 01 тоот тушаалаар батлагдсан агентлагийн 2014 оны ажлын үр дүнг үнэлэх үзүүлэлтийг ханган ажиллахаар “Бид манлайлна” гэсэн оны зорилтыг тавин ажиллаж байна. Ийнхүү сахилга, хариуцлагыг дээшлүүлж, манлайллыг өндөржүүлэх ажлыг Газрын дарга буюу Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээний хавсралтаар батлагдсан “Байгууллагын 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусган хэрэгжүүлж байна.

Ингээд 2014 оны зорилт, үйл ажиллагааны хүрээнд байгууллагын хэмжээнд авлигын эсрэг үйл ажиллагааг зохион байгуулсан тухай жилийн тайланг дор дурдсанаар дэлгэрэнгүй тайлагнаж байна. Тайланд тусгасан мэдээ, мэдээлэл нь 2013 оны 11 дүгээр сарын 15-наас 2014 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх нэг жилийн хугацааг хамруулав.

ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Худалдан авах ажиллагааны газар нь төрийн худалдан авалтыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, ил тод нээлттэй явуулах боломж нөхцлийг бүрдүүлэхэд онцгой анхааран ажиллаж байна. Тус байгууллага нь “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөө”, “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлын 2014 оны нэгдсэн төлөвлөгөө”-г баталж, хэрэгжүүлэн ажиллав.

Хүснэгт 2.1. Авлигын эсрэг үйл ажиллагаа, Сургалт, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт

№	Хэрэгжилтийн явц	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	Сургалт, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт
1	Нийт хэрэгжүүлэх арга хэмжээ	27	10
2	Бүрэн хэрэгжиж биелсэн – /Б/	23	8
3	Хэрэгжих шатандаа - /ХШ/	4	2
	Үүнээс: 90%	4	2
	70%	-	-
	50%	-	-
	30%	-	-
	10%	-	-
4	Хэрэгжүүлэх хугацаа болоогүй хүлээгдэж байгаа - /ХБ/	-	-
5	Тасарсан - /Т/	-	-
	Хэрэгжилтийн хувь	98,5	98,0

Төлөвлөгөөний хэрэгжилтийг 11 дүгээр сарын 14-ний өдрийн байдлаар тооцсон дүнгээс үзэхэд оны эцэст төлөвлөсөн ажлууд бүрэн биелэх боломжтой байна. Төлөвлөгөөний биелэлтийг энэхүү тайланд хавсарган хүргүүлэв.

Авлигын эсрэг үйл ажиллагааны талаарх мэдээллийг дараах байдлаар багцлан тайлагнаж байна.

2.1. АЛБАН ХААГЧДЫН МЭДЛЭГ, ОЙЛГОЛТЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АЖИЛ

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөнд албан хаагчдын энэ чиглэлийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг сахих, Төрийн албан хаагчийн ёс зүйг эрхэмлэх чиглэлээр тодорхой заалтуудыг тусган хэрэгжүүлэв.

2014 онд албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, ёс суртахуун, ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөх асуудлаар нийт 5 сургалт, лекцийг зохион байгуулав. Үүнд:

1. “Авлигын эсрэг хууль, тогтоомжийг таниулах нь” сургалт, 2014 оны 01 сарын 15. *АТГ, Нийгмийн дэвшил, эмэгтэйчүүд, хөдөлгөөн ТББ, АНУ-ын Азийн сан Олон улсын байгууллага,*
2. “Төрийн жинхэнэ албан хаагчийн эрхэмлэх зүйл, ёс суртахуун” лекц. 2014 оны 01 сарын 30. *Илтгэгч: Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга н.Цэдэндамба,*
3. “Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал” лекц. 2014 оны 05 сарын 07. *Илтгэгч: Удирдлагын академийн багш, доктор (PhD.) н.Цолмонтуяа,*
4. “Байгууллагын соёл, ёс зүй” лекц. 2014 оны 11 сарын 05. *Илтгэгч: Удирдлагын академийн багш, доктор (PhD.) н.Цолмонтуяа,*
5. “Хувь хүний ёс зүй, ёс суртахуун, шударга ёс” лекц. 2014.11.12. *Илтгэгч: Бурханы Шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн Хамба лам Д.Чойжамц.*

Байгууллагын хэмжээнд хууль эрх зүйн хэрэгжилтийг сайжруулах, албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хууль эрх зүйн дэмжлэг тусалцаа



Зураг 2.1.1. Сарын аяны нээлтийн үеэр

үзүүлэх, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж, улмаар зөрчилгүй хамт олон болох зорилгоор “Хууль эрх зүйн зөрчилгүй хамт олон” нэг сарын аяныг 2014 оны 10 дугаар сарын 20-оос 11 дүгээр сарын 20-ыг хүртэл зохион байгуулж байна (Удирдамж, аяны хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг тайланд хавсаргав). Аяны хүрээнд байгууллагын зохион байгуулалтын нэгж - хэлтсүүдэд дарцаг аялуулж, аяны дарцаг хүлээн авсан хэлтсүүд тодорхой бүтээлч ажлуудыг зохион байгуулж байгаа нь

хэлтсүүдийн идэвх оролцоо нэмэгдсэн ажил болов.

Байгууллагын дунд шатны менежер болох хэлтсийн дарга нар “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх хүсэл эрмэлзлэл”-ээ албан хаагчдын өмнө манлайлан илэрхийлэх арга хэмжээг 2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулав. Өнгөрсөн 2013 онд тус байгууллагын дарга, дэд дарга нар ийм эрмэлзлэлээ илэрхийлсэн бол өнөөдрийн байдлаар байгууллагын нийт удирдлагууд ийнхүү албан хаагчдаа манлайлан, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхаа илэрхийлээд байгаа юм. Энэ нь байгууллагын албан хаагчдад үлгэр жишээ болж, тэднийг ийм амлалтад нэгдэх, ёс суртахуун, ухамсартайгаар аливаад хандаж, төрийн албан хаагчийн нэр хүндийг хамгаалан ажиллахад эерэг нөлөөлөх арга хэмжээ болов.



Зураг 2.1.2. Хэлтсийн дарга нар “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх хүсэл, эрмэлзлэлээ илэрхийлж байгаа нь

Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх өөр нэг арга хэмжээ болох “Дэвжээ” тэмцээн-уралдааныг нийт албан хаагчдыг хамруулан 2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр тусгай удирдамжийн дагуу зохион байгуулав (Уг арга хэмжээний удирдамж, хөтөлбөрийг тайланд хавсаргав). “Дэвжээ” тэмцээнийг зохион байгуулснаар албан хаагчдын багаар ажиллах чадвар, бүтээлч болон логик сэтгэлгээ, танин мэдэхүйг хөгжүүлж, Худалдан авах ажиллагааны болон төрийн захиргааны байгууллагын албан хаагч бүрийн мэдвэл зохих хууль, тогтоомж, дүрэм, журмыг судлуулан таниулах, энэ чиглэлийн мэдлэгээ ахиулахад ихээхэн ач холбогдолтой арга хэмжээ болов.



Зураг 2.1.3. Хууль эрх зүйн мэдлэг сорих “Дэвжээ” тэмцээний үеэр

Байгууллагын албан хаагчдад хуулийн заалтын хугацаа сануулах, авлигын эсрэг хууль, тогтоомжтой холбоотой мэдээ, мэдээлэл, арга зүйг байгууллагын дотоод сүлжээ, мэдээллийн самбар, нийт албан хаагчдын хурал, цуглаан, удирдлагын шуурхай хурал зэргээр дамжуулан мэдээлж ажилласан. Байгууллагын ЭБАТ нь 2014 оны 05 дугаар сарын 09-ний өдөр АТГ-т зохион байгуулагдсан “ЭБАТ-ын цаг” сургалт, семинарт хамрагдаж, мэдээлэл, арга зүйн дэмжлэг авч ажиллав.

Тус байгууллага нь АТГ-аас тайлангийн хугацаанд 2 удаа холбогдох гарын авлага, товхимол хүлээн авсныг орон нутгийн болон тус байгууллагын албан хаагчдад семинар, сургалтын үеэр хуваарилан тараасан болно. Ном, товхимол авсан албан хаагчдыг бүртгэлийн хуудсаар бүртгэн гарын үсэг зуруулсан баримтыг хавсаргав. Үүнд:

1. 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдөр “Орон нутгийн удирдах ажилтны сургалт, семинарыг зохион байгуулсан ба түүнд оролцсон 67 албан хаагчид АТГ-аас ирүүлсэн “Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах нь” гарын авлага,

2. 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр АТГ, НДЭХ ТББ-ын зохион байгуулсан “Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах нь” нийтийн албан тушаалтанд зориулсан сургалтад хамрагдсан тус байгууллагын 47 албан хаагчдад гарын авлага, ном, товхимол тараан олгосон.



Зураг 2.1.4. АТГ-аас ирүүлсэн гарын авлага, ном, товхимол

2.2. МЭДҮҮЛЭГ, МЭДЭГДЭЛ БҮРДҮҮЛЭЛТИЙН АЖИЛ

Тайлант жилийн 02 дугаар сарын 15-ны дотор (хуулийн хугацаанд) байгууллагын мэдүүлэг гаргагч 49 албан хаагчийн 2013 оны ХАСХОМ-ыг шинэчлэн гаргаж, мэдүүлэх ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулж, 100 % хамруулсан. Улмаар 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор хуулийн хугацаанд багтааж 2013 оны мэдэгдэл, мэдүүлгийн бүрдүүлэлтийн мэдээ, тайлан, ЭБАТ-ын 2013 оны ажлын тайланг гарган АТГ-т хугацаанд нь хүргэж мэдээлсэн. Хуулийн хугацаанд 2013 оны ХАСХОМ-ийг шинэчлэн гаргаагүй, хууль зөрчсөн асуудал гараагүй. 2013 оны мэдүүлэг, мэдэгдэл цаасан сууриар болон мэдүүлэг бүрдүүлэлтийн цахим системд бүрэн бүртгэгдэн хууль, журмын дагуу хадгалагдаж байна. Мөн 2013 оны ЭБАТ-ын бүртгэлүүд цаасан болон цахим системийн бүртгэлүүд бүрэн хийгдсэн болно.

2014 оны мэдүүлэг, мэдэгдэл гаргах үйл явцад хяналт тавин ажиллаж, ХАСУМ, хөрөнгө орлогын их хэмжээний өөрчлөлтийг хуулийн хугацаанд мэдүүлэх талаар албан хаагчдад хууль сануулах арга хэмжээг авч ажилласан. 2014 оны ЭБАТ-ын бүртгэлүүдийг хууль, журам, зааврын дагуу тухай бүр хөтөлснөөр шаардлагатай бүртгэл - мэдээллийн сан үүссэн бөгөөд тухай бүр уг санд баяжилт хийж хэвшээд байна. Он гарсаар албан тушаалд шинээр нэр дэвшигч 7 иргэн, албан тушаалтанд хамаарах хувийн ашиг сонирхлын 8 урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг АТГ-аар хянуулан, зохих шийдвэрийг гаргав. 2014 он гарсаар 11 дүгээр сарын 12-ны өдрийн байдлаар нийт 116 үнэлгээний

хороонд ажилласан албан хаагчид, ТББ-ын төлөөллөөс ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх талаарх 1467 мэдэгдлийг байгууллагын ЭБАТ-д хүлээн авч, мэдүүлэг бүрдүүлэлтийн цахим системд бүртгэж байна. Тайлангийн хугацаанд ашиг сонирхлын зөрчил үүсэх тухай 2 мэдэгдэл, тайлбарыг хүлээн авч, үнэлгээний хорооны гишүүнээс чөлөөлөн зөрчил үүсэхээс сэргийлсэн хязгаарлалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэв.

Тайлант хугацаанд холбогдох хууль тогтоомж, түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийг байгууллагын албан хаагчдад мэдээллийн самбар, дотоод сүлжээ, удирдлагын шуурхай хурал, нийт ажилтнуудын хурал ба биечлэн зөвлөгөө, зөвлөмж өгөх зэрэг сувгаар сурталчлан таниулж, мөрдүүлэн хэрэгжүүлж ажиллав. УИХ-аас 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр баталсан Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу хөрөнгө орлогодоо орсон их хэмжээний өөрчлөлтийг 7 албан хаагч мэдүүлсэн бол шинээр албан тушаалд томилогдсон 7 албан хаагч хуулийн хугацаанд ХАСХОМ-ыг анх шинээр мэдүүлэв.

Албан хаагчдын 2013, 2014 оны цаасан суурьт ХАСХОМ тус бүрд “НУУЦ” тэмдэг дарж, лацтай шүүгээнд хадгалан, хувь хүний нууцад хамаарагдах уг баримт материалын хадгалалт хамгаалалтыг сайжруулан ажиллав.

2.3. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Худалдан авах ажиллагааны газар нь “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Монгол улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор баталсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт” болон бусад холбогдох хууль, тогтоомжийн дагуу байгууллагын ил тод, нээлттэй байдал, үзүүлж буй үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх талаар тодорхой үр дүнтэй ажлуудыг авч хэрэгжүүлж байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Худалдан авах ажиллагааны газар нь 2013 оны 408 дугаар тогтоолоор батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2014 онд зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд эрх шилжиж ирсэн зарим төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг чиг үүргийн дагуу зохион байгуулан ажиллаж байна. Нийт зохион байгуулагдах төсөл, арга хэмжээний 96,2 хувьд нь (10 дугаар сарын 21-ний байдлаар) тендер шалгаруулалтын ажлыг зохион байгуулж, бүрэн хэрэгжсэн ба хэрэгжих шатанд байна. Үүнээс, нийт ажлын 89,1 хувьд төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж дуусан буюу гэрээ байгуулсан ба холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт гэрээ байгуулах мэдэгдлийг тус газраас хүргүүлээд байна. 2014 оны 10 дугаар сарын 17-ны дүнгээр, ХААГ-т зохион байгуулсан тендер шалгаруулалтын дүнд 19,5 тэрбум төгрөгийн төсвийн хэмнэлт гарсан үр дүнтэй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Тендерийн будлиан, авлига, хээл хахуулийг халах зорилгоор төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг 100 хувь цахим хэлбэрт шилжүүлэх тухай” тусгасан зорилтыг хэрэгжүүлэхээр ХААГ-аас тайлант жилд ХААГ-т зохион байгуулах тендер шалгаруулалтын 80-аас доошгүй хувийг, орон нутагт зохион байгуулах тендер шалгаруулалтын 10-аас доошгүй хувийг тус тус

цахим хэлбэрээр зохион байгуулахаар төлөвлөсөн ба ХААГ нь 2014 онд худалдан авах ажиллагааг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулав. 2014 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар Нийслэл, Баян-Өлгий, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймаг, Хан-Уул дүүрэг тус тусын зохион байгуулах ажлын 37 хүртэлх хувийг цахим хэлбэрээр зохион байгуулсан үр дүнтэй байна.

Цахим худалдан авах ажиллагааны системийг нэвтрүүлснээр нээлттэй, үр ашигтай, шударга, ил тод байдал нэмэгдэж, тендер зохион байгуулах зардал буурах, төсвийн үргүй зардал багасах, худалдан авах ажиллагааны хяналтыг дээшлүүлэх зэрэг олон давуу талыг бий болгож байна.

Дээрх үндсэн үйл ажиллагааг явуулах чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээн дэх болон төрийн захиргааны байгууллагын хувьд төрийн албатай холбоотой үйл ажиллагааны нээлттэй байдлын талаар дор дэлгэрэнгүй тайлагнав.

2.3.1. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой иргэдийн мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор www.procurement.gov.mn, www.e-tender.mn домэйн нэрүүд дээр байгууллагын вэб хуудсыг байршуулан ажиллуулж байгаа бөгөөд байгууллагын эрхэм

The screenshot shows the website of the Mongolian Procurement Agency. The main content area displays tender information for 'ХААГ-2014-XXVI.1.37'. The tender title is '35 кВ-ын 25 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Баян-Өлгий, Сагсай, Улаанхус сум/'. The tender was published on 2014-04-02 and the deadline is 2014-05-02 at 15:30:00. A 'Тендерийг нээсэн' (Tender opened) button is visible.


#	Тендер оролцогчийн нэр	Багцан нэр	Гэрээ байгуулсан дүн	Гэрээ байгуулсан огноо
1	Монкас ХХК	Багц	1,889,698,000₮	2014-05-30

#	Тендер оролцогчийн нэр	Багцан нэр	Санал болгосон үнэ	Шалгараагүй шалтгаан
1	Хасу мегаватт ХХК	Багц 0	1,999,959,943₮	Тендерийн баталгааны хугацаа дутуу, Татарын ертэй.
2	Мастер энержи ХХК	Багц 0	1,728,961,774₮	Ижил төстэй ажлын туршлагагүй, Тншалгааны гашууны Улсын бүртгэлийн гэрчилгээний хугацаа дууссан.

Зураг 2.3.1. Байгууллагын цахим хуудсанд тендерийн үр дүнг ил тод мэдээлж байгаа нь

зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, цаг үеийн мэдээ мэдээлэл, зохион байгуулж буй төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны явц, түүний үр дүнгийн талаар мэдээллийг оруулж, тогтмол баяжуулан ажиллаж байна. Байгууллагын үйл ажиллагаа, төрийн худалдан авах ажиллагааны талаар иргэд, олон нийтэд мэдээллийг ил тод хүргэх хүрээнд ХААГазар болон аймгуудын 2014 оны Худалдан авах ажиллагааны


төлөвлөгөө, улирлын тайлан, тендер шалгаруулалтыг зохион байгуулахтай холбоотой бүхий л мэдээллийг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас www.e-procurement.mn, цахим худалдан авах ажиллагааны систем www.meps.gov.mn, ХААГ-ын www.e-tender.mn цахим хуудсанд тус тус байршуулж, олон нийтэд нээлттэй мэдээлсэн. Энэ ажлыг эрчимжүүлэх зорилгоор Газрын даргын 2014 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн Б/69 дүгээр тушаал гарч, тендер шалгаруулалтын үр дүнг тодорхой мэдээлэх талаар арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.



Зураг 2.3.2. Цахим худалдан авах ажиллагааны систем www.meps.gov.mn-д шалгарсан компаний материалыг ил тод байршуулж байна.

Ингэснээр тендерт шалгарсан болон шалгараагүй компаниудын тендерийн материалыг ил тод цахим хуудсанд байршуулж байгаа нь олон нийтээс гарах хардлага, буруу, ташаа мэдээллийг багасгаж, тендерт оролцогчдын гаргаж болох гомдол үндэслэлтэй байх, мэдээллийн ил тод байдлыг хангахад чиглэсэн чухал ач холбогдолтой арга хэмжээ болов. Цахим худалдан авах ажиллагааны систем www.meps.gov.mn-д 2014 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар Худалдан авах ажиллагааны газраас цахим хэлбэрээр зарласан 115 төсөл, арга хэмжээний 174 багц ажлын тендер шалгаруулалтын үр дүнг оруулж, шалгарсан компанийн холбогдох баримт бичгийг байршуулав.

Худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулагдаж байгаа тендерийн хяналтын төсвийг цахим хуудсанд ил тод байршуулан олон нийтэд мэдээлж байна. Энэ нь хэт өндөр төсөвтэй тендерийн санал ирж, тендер хүчингүй болохоос сэргийлэх, оролцогчдын үнийн санал хяналтын төсвийн хязгаарын зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү гарахгүй болж байгаа нь улсын төсвийн хөрөнгийг хэмнэх, авлига, ашиг сонирхлын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой санаачилга болов.



Зураг 2.3.3. Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас www.e-procurement.mn-д тендер шалгаруулалтын мэдээлэл мэдээлэгдэж байгаа нь


“Авлигын эсрэг үйл ажиллагааны ил тод байдал”, “Захиргаа, удирдлагын хэлтсийн мэдээллийн самбар”, “Бичиг хэргийн булан” зэрэг самбаруудыг тогтмол ажиллуулан албан хаагчид, иргэд, олон нийтэд хамааралтай шуурхай мэдээ, мэдээллийг хүргэн ажиллав.

Авлигын эсрэг хууль тогтоомжийг албан хаагчдад болон тус байгууллагаас худалдан авах ажиллагаатай холбоотой төрийн үйлчилгээ авч байгаа иргэд, олон нийт, хэрэглэгчид тус байгууллагын цахим хуудас www.e-tender.mn, байгууллагын дээр дурдсан мэдээллийн самбар зэргээр дамжуулан сурталчилж байна. Байгууллагын вэб хуудсын мэдээллийг иргэдэд ойлгомжтой болгох, мэдээллийн ил тод байдлыг хангах үүднээс ил тод байдлыг илтгэх шалгуурыг хангахуйцаар шинэчлэн сайжруулах арга хэмжээ авч ажиллав. Вэб хуудсанд АТГ-ын цахим хуудас, Мэдүүлэг бүрдүүлэлтийн цахим системийг холбосноор тус байгууллагын цахим хуудсанд хандсан хэрэглэгчид авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулан сурталчлах хялбар боломж бий болсон.



Зураг 2.3.4. Ил тод байдлын самбар

2013 оны 12 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан орон нутгийн ХААА-ны удирдах ажилтны сургалт, семинарын үеэр Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдын үүрэг, оролцоо, хариуцлагын талаар, мөн “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг хэрхэн гаргах талаар таниулан семинар өгч, холбогдох аргазүйн туслалцаа үзүүлэх зорилгоор үзүүлэн материал бэлтгэж сурталчлав. Мөн 2014 оны 09 дүгээр сард 21 аймгийн ХААА-ны ажил байдалтай газар дээр нь танилцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, үйл ажиллагаанд нь хяналт тавих ажлын хүрээнд Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын талаар зөвлөн туслав.



Зураг 2.3.5. Мэдээллийн самбаруудаар байгууллагын үйл ажиллагааг ил тод мэдээлж байгаа нь


2014 онд нийт 2 удаа нээлттэй өдөрлөгийг Чингисийн талбайд, “Ард түмэн Та – Хаан” арга хэмжээг Зүүн бүсийн Дорнод аймагт, худалдан авах ажиллагааны бүсийн сургалтыг 3 бүсэд, “Шилэн тендер” арга хэмжээг тайлангийн хугацаанд 2 удаа (2013 оны 12 дугаар сарын 10, 2014 оны 01 дүгээр сарын 24-нд) тус тус Засгийн газрын оролцоотойгоор зохион байгуулж, эрхлэх асуудлын хүрээний үйл ажиллагааг хэрэглэгч, иргэд, олон нийтэд мэдээлэн сурталчлав. Энэ талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудсанд мэдээлсэн. (Эдгээр арга хэмжээний талаар энэхүү тайланд хавсаргасан төлөвлөгөөний биелэлтүүд, тухайн арга хэмжээний тайлан зэрэг баримт, материалаас дэлгэрэнгүй үзнэ үү).

Нээлттэй өдөрлөг, “Шилэн тендер” – 1, 2 арга хэмжээнүүдийн үеэр цахим худалдан авалт, цахим дэлгүүрийн талаарх хэвлэмэл хуудас, сурталчилгааны материал хэвлүүлэн тарааж, сурталчиллав.




Зураг 2.3.6. Сурталчилгааны материал, мэдээ мэдээлэл

Монгол Улсын Ерөнхий сайдын 2013 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 94 дүгээр захирамжаар “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт ХААГ-ын холбогдох албан тушаалтнууд оролцсон бөгөөд Сангийн яамтай хамтран ажиллаж, төслийг Монгол Улсын Шадар Сайдад танилцуулан саналыг нь тусгаж бэлтгэсэн. Орон нутгийн ХААА-аас хуулийн төсөлд санал авч, тусгав. 2013 оны эцсээр хуулийн төсөлд иргэдээс санал авах зорилгоор байгууллагын цахим хуудсанд төслийг байршуулсан. ЗГ-ын хуралдаан, УИХ-д хэлэлцүүлэх асуудал нь ХААГ-аас үл хамааран 2013 оноос хойш хүлээгдэж байна. Харин 2014 онд Эдийн засаг, хөгжлийн яамнаас боловсруулсан “Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тус байгууллагаас санал өгөв. Энэ хуулийн төсөлд цахим хуудсаар дамжуулан иргэдийн санал өгөх боломжийг бий болгож, хуулийн төслийг байгууллагын **e-tender.mn** сайтад тавин, иргэд, олон нийтийн саналыг авч байна.



Зураг 2.3.7. Хуулийн төсөлд олон нийтээс санал асуулга авч байгаа нь

Тус агентлаг нь нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргадаггүй, худалдан авах ажиллагаа хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болох Сангийн яамнаас гаргасан шийдвэр, журмыг үйл ажиллагаандаа барин ажилладаг. Харин худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахад чиглэсэн, байгууллагын үйл ажиллагааны хүрээнд мөрдөх дараах эрх зүйн актыг боловсруулан ажиллаж, www.able.mn байгууллагын удирдлагын цогц систем - дотоод сүлжээнд байршуулан албан хаагчдад мэдээлж, үйл ажиллагаандаа мөрдөж байна. Үүнд:



Зураг 2.3.8. Байгууллагын дотоод сүлжээнд албан хаагчдад зориулан дотоод мэдээллийг ил тод мэдээлж байгаа нь

1. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчтой гэрээ байгуулсаны дараа тендерийн материалыг цахим худалдан авалтын систем meps.gov.mn –д тавьж

нийтэд мэдээллэх баримт бичгийн жагсаалтыг ХААГ-ын даргын 2014 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Б/69 дүгээр тушаалаар баталж, олон нийтэд мэдээллийг түргэн шуурхай, ил тод хүргэн ажиллаж байна.

2. Тендер шалгаруулалтын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор албан бичгүүдийн жишиг загварыг ХААГ-ын даргын 2014 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Б/70 дугаар тушаалаар баталсан. Уг жишиг загваруудыг мөрдсөнөөр тендерийн үнэлгээний хорооноос гарч буй шийдвэрүүд холбогдох хуулийн хүрээнд боловсруулагдан, тендерт оролцогч аж ахуй нэгжүүдэд хүргэгдэж байна.
3. 2014 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн Б/68 дугаар тушаалаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрын “Албан хэрэг хөтлөлт, архивын журам”-ыг холбогдох хууль, журам, заавартай уялдуулан боловсруулж батлан, уг журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.
4. ХААГ-ын даргын 2014 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн Б/71 дүгээр тушаалаар “Оны шилдэг хэлтэс, ажилтан шалгаруулах журам”-ыг батлан дотоод үйл ажиллагаанд мөрдөж эхлээд байна.

Худалдан авах ажиллагааны газар нь Сангийн сайдын 2013-04-19-ний өдрийн 84 дүгээр тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам”-ын дагуу Худалдан авах ажиллагааны чиглэлээр суурь мэдлэг олгох сургалтад хамрагдсан оролцогчид шаардлагатай мэдлэг эзэмшсэн болохыг гэрчилсэн (А3) гэрчилгээг шалгалтад тэнцсэн тохиолдолд олгодог. Сургалтыг Сангийн яамнаас эрх авсан мэргэжлийн ТББ зохион байгуулдаг. 2014 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар улсын хэмжээний дүнгээр тайлант онд нийт 2699 хүн А3 гэрчилгээ авсан ба үүнээс орон нутагт 39 удаагийн сургалт зохион байгуулагдсанд нийт 2612 хүн хамрагдсанаас 1265 хүн шалгалтад тэнцэж А3 гэрчилгээ авсан байна. Сангийн яамны дээрх журам ба гэрчилгээ авсан хүмүүсийн нэрсийг ХААГ-ын цахим хуудсанд ил тод зарлан мэдээлж байгаа ба гэрчилгээний хүчинтэй хугацаа 3 жил байх талаар уг журамд заасан байгаа. А3 гэрчилгээ авсан албан хаагч, иргэн өөрийн харьяалагдах нутаг дэвсгэр дэх төрийн болон ТББ-ыг төлөөлөн үнэлгээний хороонд орж ажиллаж байна.

Тус байгууллагад чиг үүргийн дагуу нууцад хамаарахаас бусад дараахь 3 төрлийн бүртгэлийг хөтөлж байна. Үүнд:

1. Цахим тендерт оролцохоор бүртгүүлж, хувийн нууцлалын код (PKI) авсан ААН-ийн бүртгэл. 2014 онд нийт 1414 ААН бүртгүүлж цахим тендерт оролцох боломжтой болсон байна. Бүртгэлийг байгууллагын цахим хуудсанд мэдээлсэн.
2. ХААГ-ын 2014 онд зохион байгуулсан тендер шалгаруулалтад 702 ААН оролцсон. Тэдгээр ААН-ийн бүртгэл (жагсаалтаар гарах боломжтой), цахим худалдан авах ажиллагааны системд тодорхой харагдана. Байгууллагын цахим хуудсанд жагсаалтаар мэдээлсэн.
3. Үнэлгээний хороонд сонгогдон ажилласан ТББ, тэдгээрийн төлөөллийн бүртгэл, мэдээлэл.

Үнэлгээний хороонд ХААГ, ТББ-аас оролцож байгаа төлөөллийг 2014 онд санамсаргүй түүвэрлэн сонгох арга хэрэглэн сонгож байгаа нь олон нийтээс гарч болох үндэслэлгүй гомдол, гүтгэлгээс зайлсхийж, төрийн худалдан авалтыг будлиангүй, шударга зохион байгуулж, авлига, ашиг сонирхлын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд ихээхэн ач холбогдолтой ажил болж байна. 2014 онд ХААГ-т зохион байгуулагдсан



Зураг 2.3.9. ТББ-уудтай гэрээ байгуулж байгаа нь

худалдан авах ажиллагааны нийт 143 үнэлгээний хороонд давхардсан тоогоор 62 ТББ, мэргэжлийн холбоодын 264 төлөөлөл олон нийтийн хяналт тавих үүрэгтэйгээр сонгогдон ажилласан байна.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх заалтыг үндэслэн Худалдан авах ажиллагааны газар 24 салбарын мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй “Худалдан авах ажиллагаанд

салбарын мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах хамтран ажиллах гэрээ” байгуулан, эдгээр байгууллагын төлөөллийг Үнэлгээний хороонд оруулан ажиллаж байна.

Хүснэгт 2.3.1. Салбарын мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй байгуулсан гэрээний жагсаалт

д/д	Байгууллагын нэрс	Гэрээ байгуулсан огноо
1	Пийшин, зуух үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбоо	2014.04.30, ТББ-2014/28
2	Зураг, төсөлчдийн холбоо	2014.03.07, ТББ-2014/27
3	Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын холбоо	2014.03.07, ТББ-2014/11
4	Гамшиг, гал түймрээс хамгаалах монголын нийгэмлэг	2014.03.07, ТББ-2014/12
5	Хүний хөгжил, судалгаа, сургалтын төв	2014.03.07, ТББ-2014/06
6	Монголын барилгачдын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо	2014.03.07, ТББ-2014/07
7	Худалдан авах ажиллагааны хөтөч	2014.03.04, ТББ-2014/08
8	Монголын эрчим хүчний барилга угсралт, засварчдын холбоо	2014.03.07, ТББ -2014/02
9	Монголын геодези, фотограммер, зураг зүйн холбоо	2014.03.07, ТББ-2014/21
10	Монголын хүнс, хөдөө аж ахуйн үндэсний ассоциаци	2014.03.07, ТББ-2014/25
11	Залуу тэнгис	2014.03.07, ТББ-2014/04
12	Тун эх ачлал	2014.03.07, ТББ-2014/03
13	Унаган нутаг цагаан уулын эзэд	2014.03.07, ТББ-2014/01
14	Үндэсний газар тариалан эрхлэгчдийг дэмжих сан	2014.03.07, ТББ-2014/19
15	Монголын эрчим хүчний инженерүүдийн холбоо	2014.03.07, ТББ-2014/18
16	Санхүүгийн шинжилгээ, үнэлгээний төв	2014.03.07, ТББ-2014/17
17	Алсын хөгжил	2014.03.10, ТББ-2014/16
18	Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо	2014.03.07, ТББ-2014/14
19	Монголын гидрогеологичдын холбоо	2014.03.09, ТББ-2014/09
20	Хөхний хорт хавдартай тэмцэх нийгэмлэг	2014.03.07, ТББ-2014/20
21	Ногоон шугам	2014.03.07, ТББ-2014/26
22	Шинэчлэл – үр дүн	2014.03.07, ТББ-2014/10
23	Монгол Улсын өрөмдлөгийн холбоо	2014.03.07, ТББ-2014/13
24	Монголын барилгачин эмэгтэйчүүдийн холбоо	2014.06.10, ТББ-2014/24



Зураг 2.3.10. ТББ-ын төлөөлтэй хийсэн уулзалтын үеэр

Үнэлгээний хороонд ажиллах шалгуур ханган бүртгэгдсэн ТББ, мэргэжлийн холбоодын төлөөлөлтэй 2014 оны 03 дугаар сарын 07-ны өдөр уулзалт зохион байгуулав. Уулзалтын үеэр ТББ, Мэргэжлийн холбоодын төлөөлөлд холбогдох хуулийн дагуу үнэлгээний хороонд хэрхэн ажиллах, тендер шалгаруулалтад олон нийтийн оролцоо, хяналт тавихын ач холбогдол, ашиг сонирхлын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх талаар холбогдох чиглэл, зөвлөмжийг өгсөн.

Үнэлгээний хороонд орж ажилласан төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөлд гэрээнд заасны дагуу урамшууллыг Үнэлгээний хорооны Нарийн бичгийн дарга нарын гаргасан цагийн бүртгэл тооцоог үндэслэн, жилийн эцэст олгохоор ажиллаж байна. Үнэлгээний хороо байгуулсан тушаалуудын хуулбар, ТББ-тай байгуулсан гэрээ, бусад материалыг энэхүү тайланд хавсарган хүргүүлэв.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулах Үнэлгээний хороонд ТББ-ын төлөөллийг оролцуулан хамтран ажиллахаас гадна тодорхой төрлийн ТББ-тай бусад асуудлаар хамтран ажиллаж байна. Тухайлбал, Нийгмийн дэвшил, эмэгтэйчүүд, хөдөлгөөн ТББ-тай албан хаагчдад Авлигын эсрэг хуулийг таниулах сургалт зохион байгуулахад нь дэмжлэг үзүүлж хамтран ажиллаж, байгууллагын нийт албан хаагчдыг сургалтад хамруулсан. Хараат бус судалгааны төв (IRIM) ТББ-ын төлөөлөлтэй уулзаж, эрсдэлтэй ажлын байрыг тодорхойлох судалгааг хийлгэх талаар ярилцаж, тэдний саналтай танилцав. Уг ТББ-ын тавьсан саналыг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр дутагдсантай холбоотой санал хэрэгжих боломжгүй болсон хэдий ч бид хамтран ажиллах оролдлого хийж, 2 удаа уулзалт зохион байгуулсан. АНУ-ын Азийн сан Олон улсын байгууллага, АТГ-ын 2013 оны 12 дугаар сарын 05-ны өдөр хамтран зохион байгуулсан “Ил тод худалдан авах ажиллагаа” дугуй ширээний ярилцлагад оролцож, ил тод худалдан авах ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, харилцан туршлага солилцсон.

Байгууллагын үйл ажиллагаа, эрхлэх асуудлын хүрээнд хийсэн ажлын талаарх мэдээ, мэдээллийг өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилан ажиллав. 2014 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн байдлаар (давхардсан мэдээллийг хэвлэлийн



Зураг 2.3.11. Байгууллагын удирдлагууд хэвлэлд ярилцлага өгч байгаа нь

мэдээллийн хэрэгслийн төрлөөр багцлав) телевизээр - 47, сонингоор - 7, олон нийтийн цахим сүлжээгээр - 16 удаа байгууллагын үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээний худалдан авалтын явцын мэдээ, сурвалжлага, ярилцлагыг олон нийтэд мэдээлэв.

Тайлант хугацаанд ХААГ-ын үйл ажиллагаа болон Засгийн газрын худалдан авах ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд шуурхай, хүртээмжтэй хүргэх үүднээс www.e-tender.mn, www.e-procurement.mn, www.zasaq.mn, www.vip76.mn, www.facebook.com/procurement.mn зэрэг цахим хуудсанд мэдээ, мэдээллийг тогтмол оруулж, олон нийтийн хүртээл болгож ажиллав.



Зураг 2.3.12. Байгууллагын үйл ажиллагааны мэдээллүүд түгээгдэж байгаа олон нийтийн мэдээллийн сүлжээ

Байгууллагын үйл ажиллагаа, цахим худалдан авах ажиллагааг ил тод сурталчлан мэдээлсэн байдлыг нотлох www.vip76.mn сайтад орсон мэдээ, мэдээллийн тайлан, Дэлхийн банкны Олон нийтийн харилцааны дотоодын зөвлөхийн “Хэвлэл мэдээллийн мониторингийн тайлан” зэргийг хавсаргав.

Тендерийн урилгыг олон нийтэд зарлан нээлттэй мэдээлэх үүднээс 2014 оны 02 дугаар сарын 16-нд ХААГ-аас зарласан тендерийн урилга, зөвлөх үйлчилгээний зарыг нийтлэх өдөр тутмын сонинг нээлттэй сонгон шалгаруулсан. Тус сонгон шалгаруулалтад өдөр тутмын 4 сонин үнийн саналаа ирүүлсэн ба Өдрийн сонин, Зууны мэдээ сонин шалгарсан. Шалгарсан сонинтой гэрээ байгуулан ажиллаж байна.



Зураг 2.3.13. Тендерийн урилгыг нээлттэй зарлах хэвлэлийн сонгон шалгаруулалт явагдаж байгаа нь

2014 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар "Өдрийн сонин", "Зууны мэдээ" сонинд зарласан, дахин зарласан, залруулга хийсэн нийт 212 тендерийн урилга, зөвлөх үйлчилгээний зар нийтлүүлэн олон нийтэд мэдээлсэн. Англи хэл дээр уншигчдад зориулж UB Post сонинд зарласан, дахин зарласан нийт 50 тендерийн урилга, зөвлөх үйлчилгээний зарыг англи хэлнээ хөрвүүлэн нийтлүүлсэн байна.

Байгууллагын удирдлагын шийдвэрийн ил тод байдлыг хангахын тулд ажил хэрэгч шийдвэрүүдийг цахим хуудсанд бүрэн эхээр нь ил тод байршуулсан ба байгууллагын дотоод үйл ажиллагаа, Үнэлгээний хороотой холбоотой шийдвэрийг жагсаалт байдлаар гарган цахим хуудсанд байршуулсан. Үнэлгээний хорооны гишүүдийн нэрс нууц байх нь авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдлийг бууруулах юм.


Худалдан авах ажиллагааны газрын www.e-tender.mn сайтын “Хууль эрх зүй” цэс худалдан авах ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журмыг дараах 5 дэд цэсийн хүрээнд байршуулан ажиллаж байна. Үүнд:

1. Сургалтын материал
2. Хууль тогтоомж
3. Журам заавар
4. Эрх зүйн актын төсөл
5. Жишиг баримт бичиг

Журам заавар дэд цэсийг 2014 онд нийт 6 удаа шинэчлэн ажилласан. Уг цэсэнд нийт 20 мэдээлэл байршуулсан.


Тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор үйлчлүүлэгчээс төлбөр, хураамж авдаггүй, харин үйл ажиллагааны орлого болох цахим тендер худалдан борлуулсны орлого ордог. Орлогын тайлан, тооцоо санхүүгийн мэдээллээр мэдээлэгдсэн.

Худалдан авах ажиллагаанд оролцогчдод төрийн үйлчилгээг шуурхай хүргэх зорилгоор холбогдох мэдээлэл, тендерийн баримт бичиг, лавлагаа, тодруулгыг “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр дамжуулан өгч, шуурхай үйлчилж байгаа бөгөөд үйлчлүүлэгчдийн тав тухыг хангасан орчин бүрдүүлэн ажиллаж байна. Байгууллагын “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр 2014 оны 3 дугаар улирлын өссөн дүнгээр тухайн жилд нийт 14809 иргэн, ААН-д үйлчилгээ үзүүлсэн нь өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 3339-өөр буурсан дүнтэй байна.



Зураг 2.3.14. Нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлэгчдийн тоо

Цахим худалдан авах ажиллагаатай холбоотой зөвлөгөө, лавлагааны тоо үйлчилгээний бусад төрлөөс өндөр үзүүлэлттэй хэвээр байна.



Зураг 2.3.15. Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйлчилгээний мэдээ

“Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр үйлчлүүлж байгаа үйлчлүүлэгчдэд төлбөр, тооцоог нэг цэгээс хийх боломж олгож, 2013 онд зохион байгуулсан сонгон шалгаруулалтын дүнд сонгогдсон Төрийн банкны салбар тус төвд үйлчилгээ үзүүлж байна. 2013 онд нээлттэй зарласан сонгон шалгаруулалтын дүнд тус банктай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байгаа ба гэрээ үргэлжлэн хэрэгжиж байна. Банкний сонгон шалгаруулсан тайлан мэдээллийг тухайн үед Төрийн өмчийн хороо, АТГ-т албан бичгээр хүргүүлэн мэдэгдсэн ба өнгөрсөн жилийн тайланд энэ талаар тайлагнан мэдээлсэн.

Байгууллагын үйл ажиллагаа, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар санал, гомдол, хүсэлт хүлээн авах хайрцаг ажиллуулж, иргэдийн санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлсэн боловч 2014 онд хайрцагаар санал, хүсэл, гомдол, шүүмжлэл ирээгүй байна. Тайлант жилд Засгийн газрын “11-11 төв”-д тайлант хугацаанд худалдан авах ажиллагаатай холбогдсон асуудлаар 50 санал, гомдол шүүмжлэл ирсэнийг хүлээн авч, 6 саналыг харьяалалын дагуу шилжүүлэн, 44 санал, хүсэлт, гомдол, шүүмжлэлд хариу өгч ажилласан. Оны эхнээс 11 дүгээр сарын 15-ныг хүртэлх хугацаанд байгууллагын албан хаагчид болон иргэдээс нийт 38 өргөдлийг бичгээр хүлээн авч, хуулийн хугацаанд 34 өргөдлийг шийдвэрлэн хариу өгсөн бөгөөд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт заасан “...Шууд шийдвэрлэх боломжгүй бөгөөд удаан хугацаанд шийдвэрлэгдэх асуудал /санхүүгийн болон орон сууцны асуудал/-аар гаргасан 4 өргөдлийг Хүний нөөцийн мэргэжилтэн тусгай бүртгэлд бүртгэн шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол болон Засгийн



Зураг 2.3.16. Санал хүсэлтийн хайрцаг

газрын “11-11 төв”-өөс худалдан авах ажиллагаатай холбогдолтой асуудлаар ирүүлсэн санал, гомдол, шүүмжлэлийн шийдвэрлэлтийн мэдээг 14 хоног тутам тогтмол Шадар сайдын шуурхайд мэдээлж ажилладаг бөгөөд оны эхнээс 22 удаа өргөдөл, гомдлын

шийдвэрлэлтийн байдлыг танилцуулсан байна. Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээллийг байгууллагын цахим хуудсанд мөн мэдээлж байна. 2014 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Чингисийн талбай дээр болсон “Ил тод худалдан авалт” нээлттэй өдөрлөгийн үеэр 200 оролцогчоос санал асуулга авч дүгнэсэн (Санал асуулгын дүнг тайланд хавсаргав).

Байгууллагын захидал харилцааны асуудал хариуцсан ажилтаны холбогдох мэдээллийг цахим хуудсанд ил тод байршуулан мэдээлсэн. Тус байгууллагын хувьд худалдан авах ажиллагааг зохион байгуулдаг ажлын онцлогоос шалтгаалан иргэдийг хүлээн авах цагийн хуваарийг нарийвчлан гаргаж мөрдөх боломжгүй. Учир нь худалдан авах ажиллагаа нь холбогдох хууль, журмын дагуу тодорхой цаг хугацааны хуваарьтай зохион байгуулагддаг тул иргэдтэй тухай бүр уулзах шаардлагатай байдаг. Нэг цэгийн үйлчилгээний төв, уулзалтын өрөөгөөр дамжуулан уулзалтыг зохион байгуулдаг.

2.3.2. Хүний нөөцийн бодлогын ил тод, нээлттэй байдал

2014 онд Цахим худалдан авах ажиллагааны хэлтэс, Ажил худалдан авах ажиллагааны хэлтэс, Сургалт сурталчилгаа, олон нийттэй харилцах хэлтсийн мэргэжилтний ажлын байрны сул орон тоог нийтэд нээлттэй зарлаж, нөхөх асуудлаар Төрийн албаны зөвлөлд 1/50, 1/513, 1/813, 1/2654, 1/2897 тоот албан бичгүүдээр хүсэлт гарган захиалга өгч, төрийн албанд анх орох иргэдийн нөөцөөс нөхөх бүртгэл явуулах, төрийн албаны мэргэжлийн шалгалт зохион байгуулах зэргээр ажилласан. Төрийн албаны зөвлөлийн вэб сайт болон өөрийн байгууллагын www.e-tender.mn сайтын “нээлттэй ажлын байр” цэс, олон нийтэд өгөх мэдээллийн “... ил тод байдлын самбар”-т сул ажлын байрны зар мэдээллийг тухай бүр дэлгэрэнгүй тавьж олон нийтэд ил тод мэдээлж ажилласан.

2014 онд Д.Номингэрэл, Ч.Ганзориг, Л.Ишжамц, Э.Баярмаа, В.Азжаргал нарын нийт 5 нэр дэвшигчийг ажилд шинээр авч, Б.Буяннэмэхийг байгууллага дотроо албан тушаалд дэвшүүлсэн бөгөөд томилгоо хийхийн өмнө Авлигатай тэмцэх газарт хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг тухай бүр хянуулж, дүгнэлт гаргуулсаны дараа томилох шийдвэр гарган ажилласан.

Агентлаг анх байгуулагдахад “Ажлын байрны тодорхойлолт” боловсруулах ажлын хэсгийг 2012 оны 11-р сарын 17-ны өдрийн 12 тоот тушаалаар байгуулж, холбогдох журам, зааврын дагуу батлагдсан орон тоо, чиг үүрэгт нийцүүлэн боловсруулж, баталсан. 2013 онд ажлын байрны тодорхойлолтод Монгол хэл бичгийн шаардлагыг нэмж тусган шинэчлэн баталсан. Өнөөдөр тус байгууллагын хэмжээнд нийт 37 (зарим ажлын байранд нэг тодорхойлолтоор ажилладаг) ажлын байрны тодорхойлолтыг батлан мөрдүүлж байна. Албан хаагчдын ажлын чиг үүргийг байгууллагын цахим хуудсанд ил тод байршуулсан.

Худалдан авах ажиллагааны газрын албан хаагчийн ёс зүйн дүрэм, ёс зүйн хорооны ажиллах журмыг Газрын даргын 2013 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/323 тоот тушаалаар батлан мөрдүүлсэн. Дүрэм, журмын төслийг 2013 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 1/3907 тоот албан бичгээр АТГ-т хүргүүлэн хянуулж, 2013 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 04/8624 тоот албан бичгээр АТГ-аас ирүүлсэн саналыг төсөлд тусган боловсруулж баталсан болно. 2014 онд энэ дүрэм, журмыг өөрчлөх шаардлагагүй тул хэвээр мөрдөн ажиллаж байгаа. Албан хаагчдад байгууллагын дотоод сүлжээ, мэдээллийн самбараар дамжуулан сурталчлан таниулсан. Зөрчлийн талаарх мэдээллийг иргэдийн санал, гомдол, хүсэлтийн хайрцагар хүлээн авах, захидал харилцааны ажилтны утас, биечлэн зэрэг боломжит

бүхий л хэлбэрээр хүлээн авах нөхцөл бүрдсэн. 2014 онд ёс зүйн асуудлаар зөрчил үүссэн болон үүсч болзошгүй тохиолдол бүртгэгдээгүй байна. Ёс зүйн дүрмийн хэм хэмжээг сахин биелүүлж, зөрчил, доголдолгүй ажиллах талаар байгууллагын албан хаагчдын хурал, цуглааны үеэр байнга сануулан анхааруулж ажиллаж байна.

“Хууль эрх зүйн зөрчилгүй хамт олон” нэг сарын аяны хүрээнд албан хаагчдын ёс зүй, шударга ёсны асуудлаар нэр хүнд бүхий лектор, доктор, судлаачдын лекц, сургамжийн үг хэлүүлэх ажлуудыг соён гэгээрүүлэх ажлын хүрээнд зохион байгуулж



Зураг 2.3.17. Тагнуулын Ерөнхий газраас хийсэн мэдээллийн үеэр

(тайлангийн 2.1.-д болон төлөвлөгөөний хэрэгжилтэд дэлгэрэнгүй тусгасан), төрийн болон байгууллагын нууцтай холбоотой асуудлаар Тагнуулын ерөнхий газрын ажилтнуудыг урьж, яриа таниулга хийлгэсэн. Байгууллагын ЭБАТ болон нийт албан хаагчид нууцын баталгаа гарган ажиллаж байна.

Төрийн захиргааны албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журам”-ын дагуу үнэлж дүгнэдэг. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлэх талаар холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн “Хөдөлмөрийн дотоод журам”-д тусгасан бөгөөд уг заалтын хүрээнд албан хаагчдын 2014 оны эхний хагас жилийн ажлыг дүгнэсэн. Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн гэрээг хагас, бүтэн жилд дүгнэхдээ хэлтэс, албан хаагч бүрийн гүйцэтгэлийг Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн дүгнэдэг уламжлал тогтсон.

Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, хариуцлагыг сайжруулах зорилгоор газрын даргын 2014 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн Б/71 тоот тушаалаар “Оны шилдэг хэлтэс, Оны шилдэг ажилтан шалгаруулах журам”-ыг батлаад байна. Мөн Цаг ашиглалтыг сайжруулах чиглэлээр 2014 оны Б/40, Б/107 дугаар тушаалыг гарган хэрэгжүүлж, 2015 оноос цалинтай холбон хариуцлагажуулахаар шийдвэрлэв. Эдгээр арга хэмжээ нь албан хаагчдын ажлын үр дүн, гүйцэтгэлийн чанарыг сайжруулж, хариуцлагыг өндөржүүлэхэд ихээхэн нөлөөтэйн дээр тэдний идэвх, санаачилга, бүтээлч байдал нэмэгдүүлсэн арга хэмжээ болж болов.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7, 18, 19 дүгээр зүйлийг сурталчлан таниулж, тодорхой ойлголт өгөх арга хэмжээ авсны зэрэгцээ газрын нийт албан хаагчдын дунд 2014 оны 11 дүгээр сард “Давхар ажил эрхлэлтийн судалгаа”-г явуулав. Судалгаанд 46 албан хаагч хамрагдсан бөгөөд давхар ажил эрхэлж буй

4 албан хаагч (Цагийн багш, өрхийн хэрэгцээний төмс хүнсний ногооны тариалан, дээд газрын шийдвэрээр мэргэжлийн зөвлөлд томилогдсон) байгаа ба тэдгээр нь хуульд зөвшөөрсөн ажил эрхэлж байна. Давхар ажил эрхлэлтийн тухай хуулийн зүйл, заалтаар таниулга, санамж бэлтгэж, байгууллагын дотоод сүлжээгээр болон бичгээр албан хаагчдад танилцуулан сурталчилж, судалгааны дүнг дотоод сүлжээ болон цахим хуудсанд ил тод мэдээлэв. Давхар ажил эрхлэлтийн судалгааг жил бүрийн 3-р улиралд авч байхаар тогтоод байгаа ба энэ жил 2 дахь удаагаа авч байна.

Худалдан авах ажиллагааны газрын хэмжээнд авлигад өртөх эрсдэлтэй ажлын байрны жагсаалтыг гаргахын тулд хөндлөнгийн буюу ТББ-аар судалгааг хийлгэх шаардлагатай гэж үзсэн тул “Хараат бус судалгааны төв” (IRIM) ТББ-д санал тавин судалгааны ажлын үнийн саналтай танилцахад зардлыг санхүүжүүлэх боломжгүй байдал үүссэн. Тиймээс байгууллагын зүгээс эрсдэлтэй ажлын байрны судалгааг албан хаагчдын дунд санал асуулга явуулан тодруулахаар судалгааны асуулга боловсруулан нийт 47 албан хаагчдад тараасан. Судалгааны дүнг нэгтгэн гаргаж, албан хаагчдад танилцуулахаар бэлтгэж байна. Судалгааны асуулгыг энэ тайланд хавсарган хүргүүлэв. Судалгааны дүнгийн мөрөөр авах арга хэмжээг төлөвлөн 2015 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх чиглэлтэй ажиллаж байна. Судалгааны дүнг 12 дугаар сарын 01-ний дотор гаргаж, байгууллагын удирдлага, албан хаагчдад танилцуулна.

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд нь авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулахад чиглэсэн ажлууд тул энэ талаарх үнэлгээг хийхдээ дурдсан төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд ба түүний хэрэгжилтийн мэдээлэлтэй холбон үзэх нь зүйтэй.

2.3.3. Төсөв, санхүүгийн ил тод байдал

Худалдан авах ажиллагааны газрын 2014 оны төсөв, санхүүгийн мэдээлэл, 2013 оны санхүүгийн жилийн эцсийн тайланд хийсэн Аудитын дүгнэлт зэргийг хуульд заасан хугацаанд цахим хуудсанд байршуулах арга хэмжээ авч, “Шилэн данс” цэсийг

The screenshot shows the website 'e-tender.mn' with a navigation menu and a main content area. The main content area features a table titled 'Урсгал зардлын гүйлгээ' (Procurement Expenditure) and a sidebar with news items.

#	Урсгал зардлын гүйлгээ	Намгдсан
1	1-р сарын урсгал зардлын гүйлгээ	2014-02-03
2	2-р сарын урсгал зардлын гүйлгээ	2014-04-03
3	3-р сарын урсгал зардлын гүйлгээ	2014-04-03
4	4-р сарын урсгал зардлын гүйлгээ	2014-05-02
5	5-р сарын урсгал зардлын гүйлгээ	2014-06-04
6	6-р сарын урсгал зардлын гүйлгээ	2014-07-05
7	7-р сарын урсгал зардлын гүйлгээ	2014-08-04
8	8-р сарын урсгал зардлын гүйлгээ	2014-09-03
9	9-р сарын урсгал зардлын гүйлгээ	2014-10-02
10	10-р сарын урсгал зардлын гүйлгээ	2014-11-03

The sidebar contains news items such as 'Худалдан авах ажиллагааны явцын мэдээ' (Status of Procurement) and 'Ногоон худалдан авалт' (Green Procurement).

Зураг 2.3.18. Байгууллагын цахим хуудас дахь “Шилэн данс”

байгууллагын цахим хуудсанд шинээр бий болгон холбогдох мэдээллээр баяжуулан ил тод мэдээлж байна. Тухайн жилийн төсвийг www.e-tender.mn сайтын “Шилэн данс” цэсэнд хуулийн хугацаанд нь байршуулж, иргэдийг мэдээллээр хангасан. Сар бүрийн 5-ны өдрийн дотор Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөн цахим хуудсанд оруулж хэвшив. Жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нь өөрийн цахим хуудас болон агентлагийн мэдээллийн самбар (Захиргаа, удирдлагын хэлтсийн самбар, Авлигын эсрэг, ил тод байдлын самбар)-д байршуулсан. 2014 оны төсвийн зарлагын хуваарьт нийт 3 удаа өөрчлөлт оруулсаныг цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангав.

Монгол Улсын Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 301 дүгээр тушаалаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”, 2013 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер зохион байгуулах журам”-д заасан тендерийн баримт бичгийн үнийг тендерт оролцогчдоос авч байна.

Тендерийн баримт бичиг худалдан борлуулсан орлогыг сар бүрийн 5-ны өдрийн дотор www.e-tender.mn сайтын “Шилэн данс” цэсэнд урсгал зардал буюу мөнгөн гүйлгээний журналд тусган байршуулж, тухайн сард хэдэн төгрөгийн санхүүжилт, хэдэн төгрөгийн баримт бичиг борлуулсан орлого орж байгааг тодорхой харуулсан. 11 дүгээр сарын 17-ны байдлаар 73,3 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого оруулсан дүнтэй байна. Төсөв, санхүүгийн холбогдох материалыг энэхүү тайланд хавсарган хүргүүлэв.

Татварын болон татварын бус орлого, Концессын зүйлийн тухай асуудал тус агентлагт хамаарахгүй болно. Мөн нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээд одоогоор байхгүй байна.

Дэлхийн банкнаас 300,0 ам долларын санхүүжилт бүхий “Худалдан авах ажиллагааны газрын ил тод байдлыг сайжруулах, чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийг 2013 оны 04 дүгээр сараас 2014 оны 12 дугаар сар хүртэлх хугацаанд хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан холбогдох баримт материалыг энэхүү тайланд хавсаргав. Цахим хуудсанд төслийн хэрэгжилтийн байдлыг байршуулан мэдээлсэн.

2.3.4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах хүрээнд ХААГ-ын зохион байгуулсан тендер шалгаруулалтын урилга, тендер шалгаруулалтын үр дүн, тендерийн нээлтийн тэмдэглэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсанд нээлттэйгээр байршуулсан ба Тендерийн урилга, зөвлөх үйлчилгээний нийт 212 зар, мэдээллийг Зууны мэдээ, Өдрийн сонин, UB post сонинууд, www.e-procurement.gov.mn, www.e-procurement.mn, www.e-tender.mn, цахим худалдан авах ажиллагааны систем meps.gov.mn цахим хуудсуудад тавьж олон нийтэд мэдээлсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4. дэх заалтын дагуу Үнэлгээний хорооны ил

тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, ТББ, захиалагч байгууллагын 2-оос доошгүй төлөөллийг оролцуулж байгаа бөгөөд 2014 онд тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд давхардсан тоогоор 264 иргэн ТББ, мэргэжлийн холбоодын төлөөлөл болон орж хамтран ажилласан.

2014 онд Үнэлгээний хороодоос тендер шалгаруулах явцад тендерт оролцогч компаниудтай холбоотой ямар нэгэн зөрчил илэрсэн тухай мэдээлэл ирүүлээгүй. Тендерт оролцогчдоос тендерийн баримт бичиг бүрдүүлэх, Татварын байгууллагын лавлагаа, банкны тендерийн баталгаа зэргийг Худалдан авах ажиллагааны газар холбогдох байгууллагуудаас авахдаа цахим хэлбэрээр шууд хүлээн авч байна.

Худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулагдаж буй тендер шалгаруулалтыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, Сангийн сайдын 2012 оны 301 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам” болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд тендер шалгаруулалтын Үнэлгээний хороод зохион байгуулж байна. Байгуулагдсан үнэлгээний хороодыг байгуулсан тушаалын хуулбар хувийг тайланд хавсаргав.

Худалдан авах ажиллагааны газрын үндсэн үйл ажиллагаатай давхцаж байгаа тул энэ бүлгийн зарим мэдээлэл “Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал” хэсэгт тусгагдсан болно.

Мөн түүнчлэн төрийн байгууллагын хувьд ХААГ-ын үйл ажиллагаанд шаардлагатай бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт буюу хөрөнгө оруулалтын ажлын тайлан, мэдээллийг байгууллагын цахим хуудас, ил тод байдлын самбараар олон нийтэд мэдээлэв. ХААГ-ын төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын ажлын нээлттэй байдлын талаар “нэмэлт материал”-д хавсаргасан.

2.4. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАРТАЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙДАЛ

Тайлант хугацаанд Авлигатай тэмцэх газарт байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, сургалт, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний хувийг хүргүүлэн төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулагдах зарим ажил, арга хэмжээнд дэмжлэг, туслалцаа авч ажиллалаа. 2014 онд Авлигатай тэмцэх газартай 3 сургалт, 1 арга хэмжээний хүрээнд хамтран ажиллаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө авсан. Үүнд:

1. 2013 оны 12 дугаар сарын 11-нд орон нутгийн худалдан авах ажиллагааны албадын удирдах ажилтны семинарын үеэр ахлах комиссар Б.Өлзий, комиссар Ж.Сарангэрэл нар оролцож, семинар өгсөн,
2. 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр НДЭХ ТББ-тай хамтарсан сургалтаар ахлах комиссар Д.Мөнхжаргал, комиссар Т.Цолмон, н.Баасандэлгэр нар оролцсон,
3. 2014 оны 03 дугаар сарын 07-ны өдөр Үнэлгээний хороонд ажиллах ТББ, мэргэжлийн холбоодын төлөөлөлтэй хамтран ажиллах гэрээ хийх үеэр ахлах комиссар Д.Мөнхжаргал авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар ойлголт өгөх мэдээлэл хийсэн,
4. 2014 оны 11 дүгээр сарын 14-нд зохион байгуулсан хэлтсийн дарга нарын “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх хүсэл, эрмэлзлэлийн илэрхийлэл, хууль эрх

зүйн мэдлэг сорих, танин мэдэхүйн, хөгжөөнт “Дэвжээ” тэмцээн - уралдааны шүүгчээр АТГ-ын ахлах комиссар Д.Мөнхжаргал оролцож ажиллав.

Тайлангийн хугацаанд 2013 оны 12 дугаар сарын 05-нд АТГ, АНУ-ын Азийн сангийн хамтран зохион байгуулсан худалдан авах ажиллагааны салбарын албан хаагчдыг оролцуулсан “Ил тод худалдан авах ажиллагаа” дугуй ширээний ярилцлагад ХААГ-ын удирдлага, албан хаагчид оролцон өөрийн байгууллагын “Сайн туршлага”-ын талаар илтгэл тавьж хэлэлцүүлсэн.

АТГ-аас ирүүлсэн зөвлөмж, шийдвэр, албан бичгийн бүртгэл хөтлөн хугацаатай бичиг болон зөвлөмж, шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллахад анхаарч байна. АТГ-аас 2014 оны 11 дүгээр сарын 10-ны байдлаар нийт 21 албан бичиг ирснийг бүртгэн авч, хариутай 8 бичгийн 7-д нь хариуг шуурхай өгч ажилласан ба нэг бичгийн хариуг өгөх хугацаа болоогүй байна. Тайлант хугацаанд АТГ-аас зөвлөмж, чиглэл өгсөн 4 албан бичгийг хүлээн авсан. АТГ-аас ирүүлсэн бичгийн бүртгэлийг хавсаргав.

Хүснэгт 2.4.1. АТГ-аас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийн шийдвэрлэлтийн байдал

№	Ирсэн бичгийн огноо, дугаар	Бичгийн утга	Шийдвэрлэлт талаарх мэдээлэл
1	2014-02-13 01/1259	Хуульд орсон өөрчлөлтийг хэрэгжүүлэх	Албан хаагчдад шуурхай хүргэж, мэдээллийн самбар, дотоод сүлжээгээр сурталчлан таниулсан. Уг өөрчлөлтийн дагуу хөрөнгө орлогодоо орсон их хэмжээний өөрчлөлтийг 7 албан хаагч өгөөд байна. Байгууллагын Ахлах нягтлан бодогчоос хуулийн хугацаанд нь 2013 оны ХАСХОМ-ийг гаргуулсан.
2	2014-08-04 02/6482	Жилийн ажлын үнэлгээнд бэлтгэл хангуулах тухай	Авлигын эсрэг байгууллагын жилийн үйл ажиллагааны үнэлгээнд бэлтгэх хүрээнд байгууллагын төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах асуудлаар удирдлагын түвшинд анхааран ажиллаж, холбогдох албан хаагчдад чиглэл өгөв. Байгууллагын цахим хуудсанд энэ чиглэлээрх мэдээ, мэдээллийг “Ил тод байдал” цэсний “Шилэн данс” буюу “Төсөв, санхүүгийн ил тод байдал”, “Худалдан авах ажиллагааны ил тод байдал” дэд цэсүүдэд холбогдох хууль, журамд заасны дагуу байршуулав.
3	2014-08-22 03/7007	Хуулийн хэрэгжилтийг хангах тухай	Хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, уг зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг АТГ-т 2014-09-30-ны өдрийн 1/2891 тоот албан бичгээр хүргүүлж, хариу мэдээлсэн. Хариу өгсөн уг албан бичгийг тайланд хуулбарлан хавсаргав.
4	2014-10-27 01/8998	Мэдээлэл хүргүүлэх тухай	Конвенцийн хэрэгжилтийг хангах асуудлаар уг албан бичигт тусгасан тайлан, зөвлөмжийн талаарх мэдээллийг хэлтсийн дарга нар, албан хаагчдад дотоод сүлжээгээр хүргүүлэн танилцуулж, албан бичигт тусгагдсан холбогдох зөвлөмжийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авлаа. Хариуг АТГ-т хүргүүлэх хугацаа болоогүй байна.

АТГ-ын холбогдох хэлтэс, байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар ирүүлсэн мэдэгдэл, зөрчил арилгуулахаар ирүүлсэн албан бичиг ирээгүй. Харин Мөрдөн шалгах хэлтсээс “Орхон их бүтээн байгуулалт консорциум” ХХК-аас ирүүлсэн хүсэлтийг хүргүүлэх тухай 2014 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 06/8827 тоот

албан бичгийг хүлээн авч, Хуулийн хэлтсээс судлан зохих хариуг 2014 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 3/3020 тоот албан бичгээр хариу өгсөн.

Завхан аймгийн Засаг дарга Ж.Жамъяантивд хандаж “Хариуцлага тооцож, хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай” АТГ-ын 2014 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 05/4014 тоот албан бичгийн хувийг тус газарт хүлээн авсан. Уг албан бичигт дурдсан Завхан аймгийн ХААА-ны даргаар томилогдсон Ж.Сүхбаатарын томилгоотой холбоотой асуудалд ХААГ-аас зохих дүгнэлтийг өгсөн боловч тус аймгийн Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэрээ өөрчлөөгүй байгаа ба уг томилгооны асуудал холбогдох хуулийн дагуу ХААГ-т шууд хамаарч шийдвэрлэгдэхгүй болно.

АТГ-аас тус байгууллагад авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн дүрэм, журам, заавар, шийдвэр үгүй байна. АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг байгууллагын дотоод сүлжээ – удирдлагын мэдээллийн цогц систем (www.able.mn)-д мэдээлэн нийт албан хаагчдад танилцуулав.

Тус байгууллагын албан тушаалтантай холбоотой Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрч, шүүхээр шийдвэрлэгдсэн гэмт хэрэг, бусад зөрчил бүртгэгдээгүй.

Тайлант хугацаанд авлигатай тэмцэх асуудлаар боловсруулж байгаа Үндэсний хөтөлбөрийн хэлэлцүүлэгт тус байгууллагын төлөөлөл оролцож, салбарын холбогдолтой асуудлаар санал бодлоо илэрхийлсэн.

Мэдүүлэг бүрдүүлэлтийн асуудлаар АТГ-ын ХШДШХэлтсийн холбогдох мэргэжилтнүүдтэй шаардлагатай үед холбогдож, мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг авч ажилласан.

2.5. ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН АЖИЛ

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс 2014 онд хийж гүйцэтгэх хяналт, шалгалтын ажлын төлөвлөгөөг оны эхэнд газрын даргаар батлуулан ажилласан. Нийт 9 хяналт, шалгалт хийж, үнэлгээ өгөн 8 дүгнэлт гаргахаар төлөвлөснөөс хяналт шалгалтын ажлын гүйцэтгэл 100 хувьтай байна. Хийсэн шалгалтын дагуу нийт 13 зөвлөмж, 1 албан шаардлага гаргаж, Үнэлгээний хороодод Нарийн бичгийн даргаар ажилласан мэргэжилтнүүдэд цаашид анхаарч ажиллах асуудлаар чиглэл, арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

Тендерийн явц удааширч байгаа болон, тендер хүчингүй болж байгаа шалтгаанд үнэлэлт дүгнэлт өгч, газрын удирдлагад танилцуулсан ба уг мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан.

Газрын даргын 2014-09-11-ний өдрийн Б/98 тушаал гарч, орон нутгийн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцаж, мэргэжил, арга зүйн зөвлөмж өгөх ажлын удирдамж баталсны дагуу 21 аймагт ХААГ-ын мэргэжилтнүүд 09 дүгээр сарын 15-наас 10 дугаар сарын 06-ны өдөр хүртэл ажиллаж, орон нутгийн ХААА-ны үйл ажиллагаанд хяналт хийлээ. Энэ хүрээнд авлигын эсрэг үйл ажиллагаанд хяналт тавьж, зөвлөгөө өгч ажиллав. Орон нутагт ажилласан дүнг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг нэгтгэн шийдвэрлэх арга хэмжээ авах талаар Сангийн яам, ШСАА-нд танилцуулахаар тайланг хүргүүлэв.

Байгууллагын дотоод аудит, хяналт, шалгалтын хүрээнд авлигын зөрчил илэрч, бүртгэгдээгүй.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.7 дахь заалтын дагуу тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх нь Сангийн яамны бүрэн эрхэд хамаардаг тул Худалдан авах ажиллагааны газарт ирсэн гомдол, хүсэлтийг хуулийн дагуу холбогдох байгууллагад нь шилжүүлэн ажилласан.

2.6. БАЙГУУЛЛАГААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ШИНЭ САНААЧИЛГА, ТОМООХОН АЖЛУУД

Авлига, ашиг сонирхлын зөрчил, иргэд, байгууллагын гомдол, маргаан гарахаас урьдчилан сэргийлэх, салбарын болон байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдал, шударга байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн дараах шинэлэг болон томоохон ажлуудыг нэрлэж байна. Үүнд:

1. Орон нутгийн нэгжийн удирдах ажилтны сургалт, семинар. 2013 оны 12 сарын 11-ний өдөр Худалдан авах ажиллагааны салбарын орон нутгийн нэгжийн удирдах албан хаагчдыг чадавхижуулах сургалтыг зохион байгуулж, 2014 оны ажлаа сахилга, хариуцлага, ил тод байдлыг хангахад чиглүүлж ажиллахад анхаарах чиглэл өглөө. Энэ хүрээнд, цахим худалдан авалтыг хэрхэн зохион байгуулах, архив, албан хэрэг хөтлөлт, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод байдлыг хангахад анхаарах асуудлаар семинар өгч, нийслэл, 21 аймаг, 9 дүүргийн 75 албан хаагчийг хамруулан чадавхижуулсан. Энэхүү сургалт-семинар нь орон нутгийн худалдан авах ажиллагааг аливаа зөрчил, доголдол, авлига, ашиг сонирхлын зөрчил гаргахгүй, шударга, хариуцлагатай зохион байгуулж, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангахад ихээхэн ач холбогдолтой, бүтээлч ажил болсон.



Зураг 2.6.1. Орон нутгийн ХААА-ны удирдах ажилтны сургалт, семинар

2. “Шилэн тендер - 2” уулзалт. “Шилэн тендер”, “Цахим дэлгүүр”-ийн талаарх мэдээллийг иргэд, ААН-д хүргэх, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор



Зураг 2.6.2. “Шилэн тендер - 2” уулзалт, арга хэмжээ

Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагвын санаачилгаар “Шилэн тендер-2” уулзалтыг 2014 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр Гадаад харилцааны яамны “Зөвшилцөл” танхимд зохион байгуулсан. Уг уулзалтыг Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой хамтран зохион байгуулсан ба арга хэмжээнд 250 гаруй ААН-гийн төлөөлөл оролцсон. Монгол Улсын Шинэчлэлийн Засгийн газраас төрийн худалдан авах ажиллагааны хүрээнд явуулж байгаа бодлого, 2014 оны худалдан авах ажиллагааны онцлог буюу тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах ажлыг олон нийтэд сурталчлан таниулж, худалдан авах ажиллагаанд оролцогч аж ахуйн нэгж, байгууллагуудыг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт, бүтээн байгуулалтын гүйцэтгэлд хариуцлагатай, өндөр бүтээмжтэй оролцох талаар тодорхой мэдээлэл өгсөн ажил болов.

3. Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хийсэн уулзалт.

Үнэлгээний хороонд ажиллахаар бүртгэгдсэн 24 төрийн бус байгууллага, мэргэжлийн




Зураг 2.6.3. ТББ-ын төлөөлөлтэй хийсэн уулзалтын үеэр

холбоодын 59 төлөөлөлтэй 2014 оны 03 дугаар сарын 07-ны өдөр уулзалт зохион байгууллаа. Уулзалтын үеэр худалдан авах ажиллагаанд салбарын мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөллийг олон нийтийн хяналт тавих чиг үүрэгтэйгээр оролцох талаар тэдгээр ТББ-ын төлөөлөлтэй “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулав. Энэ нь ТББ, мэргэжлийн холбоод гэрээний үүргээ хариуцлагатай биелүүлж, тендер шалгаруулалтад иргэд, олон нийтийг төлөөлөн ухамсартайгаар хяналт тавьж оролцох нийгмийн үүргээ нэр төртэй биелүүлэхэд чиглэсэн, тэдний идэвх,

оролцоог нэмэгдүүлсэн ажил болов. Тус арга хэмжээний үеэр Үнэлгээний хороонд ажиллахаар гэрээ байгуулсан ТББ, Мэргэжлийн холбоодын төлөөлөлд холбогдох хуулийн дагуу хэрхэн ажиллах, тендер шалгаруулалтад олон нийтийн оролцоо, хяналт тавихын ач холбогдол, ашиг сонирхлын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх талаар холбогдох чиглэл, зөвлөмжийг өгсөн. Тэдгээр нь тухайн үнэлгээний хороонд санамсаргүй түүврийн аргаар сонгогдон томилогдож, холбогдох хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх талаар мэдэгдэл өгсний үндсэн дээр олон нийтийн төлөөлөл болон ажиллаж байна.


4. Шалгарсан компанийн материалыг ил тод мэдээлж байна.

“Тендер шалгаруулалтын үр дүнг мэдээлэх тухай” Газрын даргын 2014 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн Б/69 дугаар тушаалыг гарч, тендер шалгаруулалтад шалгарсан компанийн тендерийн материалыг цахим хуудсанд ил тод байршуулан, олон нийтэд сурталчлах ажлыг хэрэгжүүлж байна. Энэ нь тендер шалгаруулалтыг шударга зохион байгуулахад чиглэсэн хариуцлагыг өндөржүүлж, Засгийн газрын агентлагийн хувьд салбартаа манлайлан, аливаа тендерийн будлиан, шударга бус байдлыг гаргахгүйгээр ажиллахад чиглэсэн санаачилгын манлайлал болох арга хэмжээг аван ажиллав.



Зураг 2.6.4. Тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан компаний материалыг www.meps.gov.mn цахим системээр дамжуулан ил тод мэдээлж байна

5. Хяналтын төсвийг ил тод болгов. Худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулагдаж байгаа тендерийн хяналтын төсвийг цахим хуудсанд ил тод байршуулан олон нийтэд мэдээлж байна. Энэ нь хэт өндөр төсөвтэй тендерийн санал ирж, тендер хүчингүй болохоос сэргийлэх, оролцогчдын үнийн санал хяналтын хязгаараас зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү гарахгүй болж байгаа нь улсын төсвийн хөрөнгийг хэмнэхэд чухал ач холбогдолтой санаачилга гэж үзэж байна.



Зураг 2.6.5. Тендерийн хяналтын төсвийг www.meps.gov.mn цахим системээр дамжуулан ил тод мэдээлж байна

6. Үнэлгээний хорооны гишүүнийг санамсаргүй түүврийн аргаар сонгодог болов. Үнэлгээний хороонд ХААГ, ТББ-аас оролцож байгаа төлөөллийг санамсаргүй түүвэрлэн сонгох арга хэрэглэн сонгож байгаа нь олон нийтээс гарч болох үндэслэлгүй гомдол, гүтгэлгээс зайлсхийж, төрийн худалдан авалтыг будлиангүй, шударга зохион байгуулж, авлига, ашиг сонирхлын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд ихээхэн ач холбогдолтой ажил болж байна.

7. “Ил тод худалдан авалт” өдөрлөг. Энэхүү арга хэмжээг өнгөрсөн онд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнг иргэд, олон нийтэд мэдээлэн, таниулах гол зорилготойгоор Чингисийн талбайд 2014 оны 06 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулав. Тус өдөрлөгт Засгийн газрын агентлаг ХААГ, нийслэлийн ХААГ, 9 дүүргийн ХАА-ны албад, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Төрийн банк, 2013 онд зохион байгуулсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд шалгарч, гэрээний үүргээ биелүүлсэн 120 гаруй аж ахуйн нэгж, 20 гаруй иргэдийн бүлэг болон худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалт зохион байгуулдаг ТББ-ууд зэрэг нийт 150 гаруй байгууллага, ААН оролцов. Уг арга хэмжээ нь Засгийн газраас зарласан “Эдийн засгийг эрчимжүүлэх 100 хоног”-ийн хүрээнд зохион байгуулагдаж байгаагаараа онцлог байсан төдийгүй тус салбарын хариуцлага, үр дүнгийн манлайллыг олон нийтэд хандуулсан ил тод, нээлттэй, томоохон арга хэмжээ болсон гэж дүгнэж байна. Өдөрлөгийн үеэр 3000 гаруй хүн уг арга хэмжээнд хамрагдсан.



Зураг 2.6.6. Нээлттэй өдөрлөгийн үеэр тендерт оролцогчдын үр дүнтэй танилцаж байгаа нь

8. Цахим худалдан авах ажиллагаа. Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тендерийн будлиан, авлига, хээл хахуулийг халах зорилгоор



Зураг 2.6.7. Цахим худалдан авах ажиллагааг нэвтрүүлэх үе шат, онцлогийг харуулсан схем

төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг 100 хувь онлайн хэлбэрт шилжүүлэхээр тусгасан. Энэ зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Худалдан авах ажиллагааны газар нь Засгийн газрын худалдан авах ажиллагаанд нээлттэй, үр ашигтай, шударга, ил тод байдлыг бий болгох, тендер шалгаруулалтыг зохион байгуулах зардлыг багасгах, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулж, улсын төсвийг үр ашигтайгаар зарцуулах, түүнд тавигдах хяналтыг дээшлүүлэхэд манлайлан, энэ үйлсэд сахилга, хариуцлагатай хандаж, тэдгээрийг үйл ажиллагааныхаа зарчим болгон

ажиллагааны мэдээ, мэдээллийг нэг системд төвлөрүүлэн нэгтгэх чиглэлээр “Цахим 2” төслийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэн хэрэгжүүлж байна. Худалдан авах ажиллагааны нэгдсэн нэг систем бий болж, худалдан авах ажиллагаанд техник технологийн дэвшлийг нэвтрүүлснээр цаг хугацаа, төсөв хөрөнгийг хэмнэх, үр ашгийг бий болгох, мэдээллийн ил тод байдлыг хангаж, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх боломжийг бий болгох юм. Төслийн хэрэгжилт 80 хувьтай, программ хангамжийн ажлууд хийгдэж дуусч байна. Ирэх 2015 оноос цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системийг ашиглаж эхэлнэ.

9. Орон нутгийн ХААА-ын ажилтай танилцаж, мэргэжил, арга зүйгээр хангав.

Орон нутгийн ажилд мэргэжил, арга зүйгээр хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавих ажлыг зохион байгуулж, 21 аймагт ажиллав. Энэ хүрээнд авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх асуудал, мэдээллийн ил тод байдлыг хангаж байгаа байдалд хяналт тавьж, зөвлөгөө дэмжлэгээр хангав.



Зураг 2.6.8. ХААГ-ын төлөөлөл Дархан-Уул аймагт ажиллаж, ХААА-ны болон холбогдох хүмүүст мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлж байгаа нь

10. Орон нутгийн худалдан авах ажиллагааны салбарын бүсийн уулзалт, сургалт, семинар, “Ард түмэн Та – Хаан” форумыг зохион байгуулав.

8, 9, 10 дугаар сард Баруун, Зүүн, Төв ба Хангайн бүсийн Худалдан авах ажиллагааны салбарын албан хаагчдын зөвлөлдөх уулзалтыг орон нутгийн албадтай хамтран Ховд, Дорнод, Дархан-Уул аймгуудад зохион байгуулав. Эдгээр бүсийн арга хэмжээнд нийт 21 аймаг, 5 дүүрэг (Багахангай, Багануур, Баянгол, Налайх, Чингэлтэй) - ийн худалдан авах ажиллагааны салбарын 140 албан хаагч оролцов. Зөвлөлдөх уулзалтаар орон нутгийн ХААА-ны удирдлагуудын тавьсан “Худалдан авах ажиллагааны явц, үр дүн, сайн туршлага, тулгамдаж буй асуудал” сэдэвт илтгэлийг хэлэлцүүлээ. Энэ үеэр мөн төрөлжсөн сургалтуудыг зохион байгуулав.

Монгол Улсын Шадар сайдын санаачлагаар жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “АРД ТҮМЭН ТА - ХААН” форумыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Худалдан авах ажиллагааны газар, Дорнод аймгийн Засаг дарга, ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба хамтран 2014 оны 09 дүгээр сарын 23-29-ний өдрүүдэд зүүн бүсийн Дорнод аймгийн Чойбалсан хотод амжилттай зохион байгууллаа.



Зураг 2.6.9. Худалдан авах ажиллагааны салбарын албан хаагчдын зүүн бүсийн зөвлөлдөх уулзалт, семинар, “Ард түмэн Та – Хаан” форум Дорнод аймагт

11. “Хууль эрх зүйн зөрчилгүй хамт олон” сарын аяныг зохион байгуулав.



Зураг 2.6.10. Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Ч.Жаргалан аяны буухиа дарцгийг хэлтэстээ хүлээн авч байгаа нь

“Хууль эрх зүйн зөрчилгүй хамт олон” аяныг 2014 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэлх нэг сарын хугацаанд зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, эрх зүйн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тодорхой ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлэв.

Аяны хүрээнд олон бүтээлч ажлууд зохион байгуулагдаж, хэлтсүүд, албан хаагчдын оролцоо, идэвх санаачилга нэмэгдэв.

о О о

ДҮГНЭЛТ

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газар нь үйл ажиллагаагаа явуулахдаа авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад ихээхэн анхаарч, өөрийн чиг үүргийн дагуу зохион байгуулж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны ил тод, шударга байдлыг хангахад хүчин чармайлт гарган ажиллаж байна.

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр байгууллагын “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөө”, “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, соён гэгээрүүлэх ажлын 2014 оны нэгдсэн төлөвлөгөө”-нд тодорхой ажлуудыг тусган жилийн турш хэрэгжилтийг хангаж, өнөөдрийн байдлаар төлөвлөгөөнд тусгасан ажлуудаа 98,5 хувиар биелүүлээд байна. Тус байгууллагын албан хаагчид тендер шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хороодод ажиллаж байдаг бөгөөд тендер шалгаруулах ажил нь цаг хугацаагаар хэмжигдэж, албан хаагчид харилцан адилгүй хугацаанд ажлын ачаалалтай ажилладаг тул оны эхний хагас жилд олон нийтээр зохион байгуулах ажлуудыг хэрэгжүүлэхэд тохиромжгүй байдал гарч байсан тул сүүлийн хагас жилд ялангуяа зохион байгуулах ёстой худалдан авах ажиллагаа цөөрч байгаатай холбогдуулан 10-11 дүгээр сард төлөвлөгөөнд тусгагдсан тодорхой бүтээлч, олон нийтийг хамарсан ажлуудыг зохион байгуулав.

Төрийн байгууллагууд Засгийн газраас төсвийн хэмнэлтийн горимд шилжиж ажиллах талаар Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоол гарсантай холбоотой тодорхой ажлуудад төсөв, хөрөнгө дутагдаж байсан. 2014 онд авлигын эсрэг үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийг тооцож үзэхэд тус байгууллага 2,4 сая төгрөгийг зарцуулсан дүн гарч байна.

Эрсдэлтэй ажлын байрыг тогтоох судалгааг өөрийн нөөц бололцоогоор хийх оролдлого хийсэн боловч эрсдэлийг хэрхэн хэмжих, ямар шалгуураар хэмжих талаар судалгааны мэргэжлийн байгууллагын дэмжлэг, оролцоо шаардагдаж байсныг дурдах хэрэгтэй. Судалгааны байгууллагад энэ асуудлаар хандаж үзсэн боловч зардлын саналыг нь төрийн байгууллагын хувьд хүчирхээргүй хэмжээний тооцоотой санал хүлээж авсан тул хэрэгжих боломжгүй болоход хүрсэн.

Цаашид тус байгууллагын зүгээс төлөвлөх ажлыг улам чанаржуулж, эрсдэлийг бууруулахад чиглэсэн, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг шинэ шатанд гаргаж ажиллахаар төлөвлөж байна.

Цаашид авах арга хэмжээ:

1. Худалдан авах ажиллагааны салбарын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох асуудлаар хууль эрх зүйн орчинд өөрчлөлт оруулахад АТГ-ын зүгээс дэмжлэг үзүүлэх,
2. Өөрсдийн хэмжээнд зохион байгуулсан авлигад өртөх эрсдэлтэй ажлын байрны судалгааны дүнд дүгнэлт хийж, АТГ-ын Сургалт, судалгааны төвөөс мэргэжлийн түвшинд эрсдэлийн хэмжээг тогтоох судалгаа хийлгэх санал тавих, Эрсдэлтэй ажлын байрны шалгуурыг тодорхой болгоход АТГ-аас анхаарч дэмжлэг үзүүлэх,

3. “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4.-т заасны дагуу тендерт шалгарсан, шалгараагүй шалтгаан үндэслэлийг тодорхой мэдээлэх ажлыг үргэлжлүүлэх,
4. Гар утсанд суурилсан аппликэйшнийг бий болгон нэвтрүүлж, түүгээр дамжуулан шалгарсан компаний ажлын гүйцэтгэл, мэдээллийг худалдан авах ажиллагааны цахим системд холбон мэдээлж, иргэд, олон нийтийн хяналтыг бий болгох, тендер шалгаруулалттай холбоотой мэдээ, мэдээллийг түгээх,
5. Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг (АЗ гэрчилгээ) олгох сургалтын шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах,
6. Тендер шалгаруулалтад шаардлагатай мэдээллийг холбогдох төрийн байгууллагуудаас цахим хэлбэрээр шуурхай авах боломжийг бүрдүүлэх,
7. Цахим худалдан авах ажиллагааны хүрээнд “Цахим дэлгүүр”-ийг ажиллуулж, төсвийн байгууллагуудын урсгал зардлаар санхүүжүүлдэг цаас, компьютер, хэвлэгчийн хор, бензин зэрэг өргөн хэрэглээний барааг нийлүүлэх ажлыг зохион байгуулан, төсвийн хэмнэлт, үр ашгийг бий болгож, ил тод байдлыг хангах,
8. Орон нутагт зохион байгуулах тендер шалгаруулалтын ажлыг 50-иас дээш хувьд хүргэж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, сургалтыг тогтмолжуулах.

ТАНИЛЦСАН:

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГА

Д.ЭНХЖАРГАЛ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ч.ЖАРГАЛАН

ТАЙЛАН БИЧСЭН:

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

Х.ЭНХЧИМЭГ